

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

2018 оны 11-р сарын 28-29

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (ГТЗ)¹ болон Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны хурал 2018 оны 11 дугаар сарын 28-29-нд Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд болон Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын (ЭЗНХЗОГ эсвэл Омбудсмений газар гэх)² чиглүүлэгч Б.Нандинчимэг оролцлоо. Мөн Эрдэнэс Оюутолгой компанийн төлөөлөл Ц.Баясгалан, малчдын төлөөллийн зөвлөх А.Орхон болон малчин М.Нямсүрэн, Ц.Эрдэнэтуяа нар өөрийн хүсэлтээр ажиглагчаар оролцсон. Хурлаар хэлэлцсэн гол асуудлууд, хэлэлцүүлгийн үр дүнг тоймлон мэдээлж байна.

Гурван талт зөвлөлийн гишүүд энэ хурлаар Ханбогд сумын засаг захиргаа, малчид болон Оюу толгой компанийн хоорондын харилцаанд түүхэн ач холбогдол бүхий томоохон шийдвэрийг гаргалаа. Зөвлөлийн гишүүд 2012, 2013 онуудад Омбудсмений газарт гаргасан малчдын гомдлыг барагдуулах арга хэмжээний хэрэгжилт хангалттай явагдаж байна гэж дүгнэсэн учраас гомдол шийдэх үйл явцыг хаах шийдвэрийг гаргасан бөгөөд дүгнэлтээ Омбудсмений газарт илгээхээр тохирсон. Ингэснээр Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээний хэрэгжилтийг Омбудсмений газраас хянах мониторингийн үе шат хаагдаж, Омбудсмений газрын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа дуусгавар болох юм. Энэ шийдвэр нь талуудын хоорондын харилцан итгэлцэл бэхжиж, хамтын ажиллагаа шинэ шатанд гарсны тод илрэл гэж гишүүд дүгнэж байна. Цаашид Зөвлөлийн үйл ажиллагаа Омбудсмений газрын оролцоогүйгээр үргэлжлэх болно. Зөвлөлийн гишүүд Малчдын гомдол барагдуулах Омбудсмений газрын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, Зөвлөл цаашид бие даан ажиллах ур чадварыг бэхжүүлж, олон улсад жишээ болохуйц маргаан шийдэх ажиллагааг чин сэтгэлээсээ хичээл зүтгэл гаргаж мэргэжлийн өндөр түвшинд чиглүүлсэн ЭЗНХЗОГ-ын багт гүн талархал илэрхийлж, амжилт хүслээ.

Нэхэмжлэлийн хорооны хурлаар малчдаас хөөн хэлэлцүүлэхээр ирүүлсэн бүх нэхэмжлэлийг хэлэлцэж шийдвэр гаргалаа. 2017 оны 6 сараас эхлэн Нэхэмжлэлийн хороо нийт 174 нэхэмжлэлийг хөөн хэлэлцэж шийдсэн байна. Үүнээс шалгуур хангасан 114 нэхэмжлэлийн хариуд нөхөх олговор олгохоор дэмжиж, 60 нэхэмжлэлийг шалгуур хангаагүй шалтгаанаар татгалзахаар шийдвэрлэсэн. Хорооны шийдвэрийг нэхэмжлэл гаргагч нарт Нэхэмжлэлийн хорооны журамд заасны дагуу мэдэгдэх болно.

¹ Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. 2017 оны 5 сарын 9-нд гомдол шийдэхийн тулд хийхээр тохирсон ажлын төлөвлөгөө бүхий Малчдын гомдлыг барагдуулах хоёр гэрээг байгуулсан. Эдгээр гэрээний хэрэгжилтэнд Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) мониторинг хийж байна.

² Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллагатай (ОТХОББ) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.

Мөн өнгөрсөн нэг жил хагасын хугацаанд хөөн хэлэлцүүлэх ажлын тухай мэдээлэл малчид иргэдэд хангалттай хүрсэн гэж Нэхэмжлэлийн хороо дүгнэсэн учраас нэхэмжлэл хүлээн авах сүүлийн хугацааг 2019 оны 1-р сарын 15-наар тасалбар болгохоор шийдвэрлэв. Иймээс хөөн хэлэлцүүлэх нэхэмжлэлийг дээр дурдсан хугацаанаас өмнө өгөхийг малчин өрхүүдэд мэдээлж байна. Улмаар Нэхэмжлэлийн Хороог бүх үндэслэлтэй нэхэмжлэлийг хэлэлцэж дууссаны дараа буюу 2019 оны 3-р сарын 30-нд татан буулгахаар тохирлоо. Нөхөн олговрын шалгуур хангасан өрхүүдэд нөхөх олговор төлж дуусах хүртэлх үйл явцыг Гурван Талт Зөвлөл хянан ажиллах болно.

Омбудсмений газрын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа дуусгавар болсонтой холбогдуулан талууд, зөвлөлийн гишүүд Зөвлөлийн үйл ажиллагаа болон Малчдын гомдлыг шийдвэрлэх үйл явцын талаар санал дүгнэлтээ хуваалцсан. Зөвлөлийн гишүүд Малчдын гомдлыг хэлэлцээний аргаар шийдвэрлэх үйл явц их үр өгөөжтэй байсныг хүлээн зөвшөөрч, хамтдаа хичээж, харилцан зөвшилцөн ажилласнаар ГТЗ “нэг баг” болон ажиллаж, харилцан итгэлцсэн орчинд нээлттэй, шударга, бүтээлч яриа хэлэлцээ явуулах механизмыг бүрдүүллээ гэж дүгнэсэн. Мөн энэхүү маргаан шийдвэрлэх ажиллагаа нь бүх талуудын идэвхтэй оролцоо түүний дотор Ханбогд сумын засаг захиргааны байнгын дэмжлэг туслалцаа, малчдын төлөөллийн тууштай шаргуу ажиллагаа, ОТ компанийн тасралтгүй дэмжлэг зүтгэлийн үр дүнд бий болсон гэдгийг гишүүд санал нэгтэй дүгнэсэн. Цаашид ГТЗ-ийн байгуулсан гэрээнүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн харилцагч талуудын бий болгосон хамтын ажиллагааг өргөн хүрээнд бататгаж, итгэлцэлийг бэхжүүлэхийн төлөө анхааран ажиллаж, бүх талууд идэвхтэй оролцох нь чухал болохыг онцлон тэмдэглэлээ

**Ханбогд сумын Гурван талт зөвлөл
Нөхөх олговрын нэхэмжлэлийн хороо**